ХӨВСГӨЛ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

**УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ**


67123. Хөвсгөл аймаг. Мөрөн сум
Утас: 70383313
www.p-hu@inspection.gov.mn


2020.06.23 № 23-03-015/162

"ББСМО" ХХК-НИЙ ЗАХИРАЛ
Б. СҮНЖИДМАА ТАНАА

Барилгын зураг төсөл хянасан тухай

Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3. дахь "Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд холбогдох хяналтын байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна." Заалт, МХЕГ-ын даргын 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/164 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтанд оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн хяналт хийх, дүгнэлт гаргах заавар", МХЕГ-ын даргын баталсан 01/57 тоот удирдамжийг үндэслэн Барилгын зураг төслийн "ББСМО" ХХК-ний 2020 73/2020 тоот хүсэлтийн дагуу Мөрөн сумын 8-р багт байрлах Авъяас сургуулийн баруун хойшоогоо өргөтгөж барих барилгын ажлын зургийг эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Ч. Одбаяр 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдөр хүлээн авч, хяналт хийв.

Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдах Авъяас спорт, урлагийн цогцолбор 320 хүүхдийн сургуулийн өргөтгөлийн барилга нь Мөрөн сумын Засаг даргын 2011 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/225 тоот захирамжаар 8950.3 $м^2$ талбай бүхий газар олгогдсон байна.

Аймгийн ерөнхий архитекторын 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн АТД-2019/03 тоот архитектор төлөвлөлтийн даалгавартай, 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн ЗД-2020/23 тоот ажлын зургийн даалгавраар, цэвэр усны 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 05 тоот, бохир усны 2018 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 16 тоот, цахилгаан, эрчим хүчээр хангах 2018 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 98/2018 тоот техникийн нөхцөлүүдтэй, аймгийн Засаг даргын тамгийн газрын захиалгаар "ББСМО" ХХК-ийн гүйцэтгэсэн ЕГ шифр: ББ-22/2020 өргөтгөлийн барилгын ажлын зураг төслийг хянахад тус барилга нь тэнхлэгээрээ 55.0м х 23.0м хэмжээтэй 2 давхар, 25м х 20м харьцаа бүхий хэмжээтэй 2 давхар спорт заал, 7.5м х 6.5м хэмжээтэй 1 давхар хүзүүвчтэй Т хэлбэр, 1 дүгээр давхар нь гонх, хонгил, жижүүрийн фост, жижүүрийн өрөө, өлгүүр, хичээлийн танхимууд, мэдээлэл зүйн кабинет, уншлагын танхим, номын фонд, халуун цех, бэлтгэх хэсэг, агуулах, хувцас солих өрөө, хооллох танхим, бохир угаах хэсэг, багш нарын өрөө, цахилгааны өрөө, ариун цэврийн өрөө, шатны талбай, спорт заал нь хонгил, эмчийн өрөө, хувцас солих өрөө, душ, дасгалжуулагчийн өрөө, агуулах, дулааны узель, 2 дугаар давхар

1283561

нь хичээлийн танхимууд, багш нарын өрөө, хөгжим бүжгийн анги, ажилчдын захиралын өрөө, захиралын туслах өрөө, туслах өрөө урлаг заал ариун цэврийн өрөө, душтай цутгамал төмөр бетон карказан бүтээцтэй, хөнгөн блокон ханатай, хуйлмал хавтгай дээвэртэй ба спорт заалны хэсэгт 2 налуут чулуун хөвөн сэндвич дээвэртэй барилга байна.

Барилгын инженер геологийн “ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ” ХХК-ийн ЗТ11-240/17 тоот 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс 2018 оны 06 дугаар сарын 15-ны хооронд хийгдсэн тэгш гадаргуутай, овойлтгүй, хөрсний ус илрээгүй, элсэн чигжээстэй хайрган ул хөрстэй, хөрсний хөлдөлтийн гүн 4.50 метр, газар хөдлөлтийн 8 баллын бүсэд баригдахаар төлөвлөгдсөн байна.

Халаалт дулаан хангамжийн эх үүсвэр нь төвийн дулаан хангамжаас хангагдхаар төлөвлөгдсөн. Уг өргөтгөлийн халаалтын систем нь доогуур түгээлттэй, 2 хоолойт мухардмал систем байхаар төлөвлөсөн байна.

Агаар сэлгэлтийн системийг анги танхимуудад ердийн систем, халуун цех, хооллох заал, спорт зааланд агаар сорох болон оруулах механик системүүд байхаар, ариун цэврийн өрөөнүүдэд агаар сорох сэнс төлөвлөсөн байна. Агаар сэлгэлтийн хоолой нь ган хоолой байхаар төлөвлөсөн байна.

Халуун, хүйтэн ус нь төвлөрсөн ус хангамжийн системээс хангагдах ба шугам сүлжээнд цайрдсан ган хоолой байхаар төлөвлөсөн байна.

Ариун цэврийн тоног төхөөрөмжөөс гарах бохир усыг бохирын цооногоор зайлуулахаар төлөвлөсөн байна. Техникийн нөхцөлд тусгагдсаны дагуу нийт 6 шинэ худаг төлөвлөсөн байна.

Гэрэлтүүлгийн сүлжээний хүчдэл 220В, гэрэлтүүлгийг өрөөний нөхцөлөөс хамааруулан ангиудын таазанд тоноглох гэрэлтүүлэгч, спорт заал, техникийн өрөө, ариун цэврийн өрөөнүүдэд ус чийгнээс хамгаалагдсан гэрэлтүүлэгч төлөвлөсөн байна.

Барилгын дотоод засалд эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан, шинжилгээний дүн, сертификаттай барилгын материалыг ашиглах нь зүйтэй.

Зураг төслийг хянаад ДҮГНЭХ НЬ:

Тус барилгын ажлын зураг нь халаалт, агаар сэлгэлт ба кондиционер БНбД 41-01-11, Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг БНбД 23-08-02, Барилга доторхи усан хангамж ариутгах татуурга БНбД 40-05-16, Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга төлөвлөлт БНбД II-66-88-ийн дагуу зурагдсан, эрүүл ахуйн заалтуудыг хангаж байна.

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Ч. ОДБАЯР